**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 06 өдөр          Дугаар А/740          Номгон

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а” Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт Хүүхдийн эрхийг хамгаалах эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Наранбаяр- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд: С.Сэржготов- Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

В.Наранчимэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын, Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Урангоо – Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнс хөдөө аж ахуйн хяналтын хэлтсийн дарга

Б.Лхагвадорж-Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

М.Саранцэцэг - Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад

Д.Балжмаа – Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Нарийн бичгийн дарга: Н.Мэндбаяр - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, хүүхдийн эрхийн улсын байцаагч

601210729

2. Дээрх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 06-25-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан зохион байгуулж, ажлын үр дүнг танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т, сумдын хэмжээнд арга хэмжээ зохион байгуулж ажлын үр дүнг дээрх хугацаанд тайлагнахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН